



# МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 18 оны 12 дугаар  
сарын 07 -ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар  
хот

## Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг нэгдүгээр, "Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө боловсруулах зааврыг хоёрдугаар, "Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, гамшгаас хамгаалах алба, байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баталсан зааврын дагуу 2019 оны 3 дугаар улиралд багтаан шинэчлэн боловсруулахыг гамшгаас хамгаалах албадын дарга, бүх шатны Засаг дарга, хуулийн этгээдийн удирдлага, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Шадар сайд



  
Ө.ЭНХТҮВШИН

Монгол Улсын Шадар сайдын  
2018 оны 10 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

## АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Нэг. Удиртгал

1.1. Энэхүү зааврын зорилго нь аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг нэгдсэн арга зүйгээр хангахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.

1.3. Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гүйцэтгэх бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд онцгой байдлын байгууллага, ЗДТГ, төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээд, сайн дурын хэсэг, иргэний төлөөлөл байна. Онцгой байдлын газар, хэлтэс нь төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

1.4. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг орон нутгийн Засаг дарга Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар жил бүр хэлэлцүүлэн орон нутгийн төсөвт тусгуулна.

1.5. Орон нутгийн Засаг дарга гамшгаас хамгаалах төлөвлөгөөний салбар төлөвлөгөө болох Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тайлагнана.

1.6. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар ашиглахдаа орон нутгийн онцлогтой нийцүүлнэ.

1.7. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг орон нутгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан боловсруулна.

1.8. Аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлага, зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж хянаж, Засаг дарга батална.

1.9. Сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар хянаж, Засаг дарга батална.

1.10. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дараах тохиолдолд тодотгоно.

- төлөвлөгөөний бүтэц, агуулгад өөрчлөлт орсон тохиолдолд,
- орон нутагт зохион байгуулж буй гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургуулиар,
- гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад илэрсэн дутагдал, сул талыг арилгах зорилгоор,
- аюулт үзэгдэл, осол болон бусад шаардлагатай үед,
- гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед.

1.11. Аймаг, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг орон нутгийн Онцгой байдлын байгууллагын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, сумын төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын дарга тус тус тодотгоно.

Хоёр. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц

2.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө дараах бүлэгтэй байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Хоёрдугаар бүлэг. Танилцуулга

Гуравдугаар бүлэг. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө

Дөрөвдүгээр бүлэг. Хариу арга хэмжээний төлөвлөгөө (аюулт үзэгдлийн төрөл бүрээр)

I. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах төлөвлөгөө

II. Гамшгаас хамгаалах дайчилгаа зохион байгуулах төлөвлөгөө

III. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө

Тавдугаар бүлэг. Сэргээн босгох төлөвлөгөө

Зургадугаар бүлэг. Хүмүүндэгийн тусламжийг зохицуулах төлөвлөгөө

Хавсралт /захирамжлалын баримт бичгийн төсөл, зарлан мэдээллийн схем, хүч хэрэгслийн тооцоо судалгаа, нөөц, хангамж, байр зүйн болон план зураг гэх мэт/

Гурав. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний агуулга,  
боловсруулах аргачлал

3.1. Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Энэ бүлэгт төлөвлөгөөний зорилго, зарчим, хамрах хүрээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг тусгана. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, Сендайн үйл ажиллагааны хүрээ

баримт бичиг, Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх стратеги зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулна.

Төлөвлөгөөний зорилго хэсэгт:

Гамшигт тэсвэртэй хот суурин, хүрээлэн буй орчныг цогцлоох, орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах асуудлыг гол зорилгоо болгож бичнэ.

Төлөвлөгөө боловсруулах зарчим хэсэгт:

Орон нутгийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн, хэрэгжих үндэслэлтэй, оролцогч талуудын харилцан ажиллагаа, уялдааг хангасан, бусад салбар төлөвлөгөөтэй уялдсан байх зарчмыг баримтлах талаар дурдана.

Хамрах хүрээ хэсэгт:

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хамрах хүрээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох аль талууд, ямар үүрэг оролцоотой оролцохыг товч дурдана.

### 3.2. Хоёрдугаар бүлэг. Танилцуулга

Энэ бүлэг нь:

- аймаг, нийслэл, сум, дүүргийн товч танилцуулга,
- тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гамшгаас хамгаалах тогтолцоо,
- хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажилладаг засаг захиргааны нэгж, хуулийн этгээдийн танилцуулга,
- эрсдэлийн үнэлгээ гэсэн хэсгээс бүрдэнэ.

3.2.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ерөнхий танилцуулга: Энэ хэсэгт дараах мэдээллийг тусгана. Үүнд:

А. Нутаг дэвсгэр, газар зүй, байгаль, цаг уурын мэдээлэл:

Энэ хэсэгт Аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зүйн байршил, томоохон уул, нуруу, нуур, мөрөнг дурдана. Нутаг дэвсгэрийн хэмжээ, сум, баг, хорооны тоо, ямар аймаг, сум, баг, хороотой хиллэдэг, хоорондын зай, агаарын температурын дундаж, цаг уурын дундаж үзүүлэлтүүд, хур тунадасны дундаж үзүүлэлтийг товч, тодорхой, зурган болон хүснэгтэн хэлбэрээр илэрхийлнэ.

Б. Хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт:

Энэ хэсэгт хүн ам, өрхийн тоо, /насны бүлэг, хүйсээр, амьжиргааны түвшин/ нягтрал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, шилжилт хөдөлгөөн, мал, амьтны тоо, улсын онц чухал объект, аж ахуйн нэгж байгууллага, нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар оруулна.

В. Дэд бүтцийн талаарх мэдээлэл:

Энэ хэсэгт зам, гүүр, төмөр зам, нисэх буудал, шатахуун түгээх станц, далан, хаалт, барилга байгууламж, усны нөөц, инженерийн шугам сүлжээ, эрчим хүч, харилцаа холбооны талаарх мэдээллийг оруулна.

3.2.2. Гамшгаас хамгаалах тогтолцоо.

Энэ хэсэгт орон нутгийн гамшгаас хамгаалах тогтолцооны бүтцийг схем зургаар үзүүлж, гүйцэтгэх чиг үүргийг товч, тодорхой бичнэ. Тухайлбал, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, Онцгой комисс, Онцгой байдлын газар, хэлтэс, албад, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллага, сайн дурын хэсэг, иргэний гүйцэтгэх үүргийг дурдана.

3.2.3. Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажилладаг засаг захиргааны нэгж, хуулийн этгээдийн тойм судалгаа, ямар чиглэлээр хамтран ажиллах, холбоо барих утас зэргийг хүснэгтээр үзүүлнэ.

3.2.4. Эрсдэлийн үнэлгээ.

Энэ хэсэгт батлагдсан журам, зааврын дагуу орон нутгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа болон үнэлгээ хийж гарсан дүгнэлтийг хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт тусгахаас гадна эмзэг байдал, чадавхын үнэлгээг мөн тодорхойлно.

Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийсэн байгууллага, оролцогч талууд, үнэлгээ хийсэн арга, аргачлалыг товч танилцуулга байдлаар дурдана. Онолын болон эрсдэлийн үнэлгээний тайлангийн хэсгийг бүтэн оруулахгүй. Шаардлагатай гэж үзвэл зураг, хүснэгт оруулна.

НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас гаргасан "Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг үнэлэх онооны карт"-ыг ашиглан орон нутгийн чадавхыг үнэлэх бөгөөд гарсан үр дүнгээс хамааран гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулна.

3.3. Гуравдугаар бүлэг. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө

Энэ бүлэгт Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан бүтцийн болон бүтцийн бус үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал хамаарна.

Орон нутгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан зөвлөмжийн дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг шаардагдах зардал, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах байгууллага, албан тушаалтныг тусгаж жил бүр төлөвлөнө. Энэхүү төлөвлөгөөг Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлөөр хянуулж, Засаг даргаар батлуулна.

Тухайлбал, эрсдэлийн үнэлгээгээр үерийн аюул болох эрсдэл өндөр түвшинд байна хэмээн тодорхойлон, далан сувгийг цэвэрлэх, сэргээх, засварлах, шинээр байгуулах, эрсдэлтэй бүсэд буй айл өрхийг нүүлгэх зөвлөмж гарсан бол энэхүү ажлыг урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд хариуцах эзэн, шаардагдах зардлын хамт тусгана.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөхдөө Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээтэй уялдуулна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл хяналт тавина.

#### 3.4. Дөрөвдүгээр бүлэг. Хариу арга хэмжээний төлөвлөгөө

##### 3.4.1. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах төлөвлөгөө

Энэ бүлэгт эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг хэрхэн шуурхай зохион байгуулах асуудлыг тусгах бөгөөд орон нутагт голчлон тохиолддог гамшгийн төрөл тус бүрээр төлөвлөгөө боловсруулна.

Тухайлбал, Зарлан мэдээлэл дамжуулах, хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх, хүч хэрэгслийг төлөвлөх, хуваарилах, онцгой комиссыг хуралдуулах, шуурхай штаб, бүлэг томилох, мэдээ мэдээлэл цуглуулах, дамжуулах, ар тал, хангалтыг зохион байгуулах гэх мэт асуудлыг хэн, хэзээ, хэрхэн зохион байгуулах талаар тусгана.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын дагуу боловсруулна.

##### 3.4.2. Гамшгаас хамгаалах дайчилгаа зохион байгуулах төлөвлөгөө

Энэ хэсэгт аюулт үзэгдлийн төрөл тус бүрээр хаанаас, ямар хүч, хэрэгсэл дайчлах, дайчилгаа явуулах удирдлага, зохион байгуулалт, хүч хэрэгслийг бүртгэх, байршуулах, дайчилгааг цуцлах зэрэг үйл ажиллагааг ямар байгууллага, албан тушаалтан хариуцахыг нарийвчлан тусгана.

Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулыг тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгавал зохино. Үүнийг орон нутгийн онцлог, зонхилон тохиолддог гамшгийн төрөл, тоо давтамжтай уялдуулан боловсруулна.

Алслагдсан сум, суурин газарт ой, хээрийн болон объектын гал, түймэр гарсан үед ажиллах хүн, техник, багаж хэрэгслийг тодорхой зааж, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдэд танилцуулан, дадлага сургуулиар тодотгож байна.

Дайчилгааны нэгдүгээр ээлжинд онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын хүч хэрэгсэл, хоёрдугаар ээлжинд гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, иргэд ажиллахаар тооцож төлөвлөнө.

#### 3.4.3. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө

Энэ хэсэгт нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах, нүүлгэн шилжүүлэх бүс, хоргодох байрыг бэлтгэх, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа, хангалтыг хэрхэн зохион байгуулах талаар тусгана. Тухайлбал, гамшгийн голомтоос иргэдийг нүүлгэн шилжүүлэх тухай зарлан мэдээлэл хүргэх, нүүлгэн шилжүүлэлтэд оролцох байгууллагууд ажлын тусгай горимд шилжин, бэлэн байдалд шилжих, иргэдийг аюулгүй талбайд цуглуулах, бүртгэл, тээвэр, маршрут, хоргодох байр, ар тал хангалт, хөгжлийн бэрхшээлтэй болон өвчтэй хүмүүс, өндөр настныг хэрхэн нүүлгэн шилжүүлэх, хэв журам, аюулгүй байдлыг хангах асуудлыг хэн, ямар байгууллага хариуцах гэх мэт асуудлыг тусгана.

Нүүлгэн шилжүүлэхдээ тухайн бүс нутагт байгаа хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг нүүлгэн шилжүүлэх дэс дарааллыг Засгийн газрын 2011 оны 340-р тогтоолоор батлагдсан гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журмын дагуу тогтооно.

Аюулт үзэгдэл ослын үед нүүлгэн шилжүүлэхдээ иргэдийг /нэрвэгдэгсдийг/ байрлуулах байрны асуудлыг хамт шийдэх шаардлагатай. Хоргодох байранд байрлах иргэдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, эрүүл мэнд, хог хаягдлын асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг урьдчилан төлөвлөнө.

#### Аюулгүй цугларах талбай

Аюулгүй талбайд цугларсан иргэдийг хэрхэн зохион байгуулалтад оруулах талаар дурдана. Иргэдийн цугларах аюулгүй талбайн план зургийг хавсралт хэсэгт оруулна.

#### Хоргодох байр

Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний нэг хэсэг нь хоргодох байрны менежментийн асуудал байна.

Төлөвлөгөөнд хоргодох байр хаана байх, хэдэн хүний багтаамжтай байх (нэг хүнд ногдох талбай-3,5м<sup>2</sup>) талаар тусгах бөгөөд хоргодох байрны бүртгэл, мэдээллийн хэсэг, эрүүл мэндийн үзлэг хийх хэсэг, хооллох хэсэг (эсвэл хоол хуваарилах хэсэг), бие засах хэсэг, дулаан хөнжил, гудас, аяга таваг, халбага сэрээ, ариун цэвэр, аюулгүй байдал, хог хаягдал гэх зэрэг асуудлыг хэн, ямар байгууллага хариуцахыг төлөвлөнө. Мөн барилга, байгууламж ашиглахгүй тохиолдолд хэдэн гэр, майхан хаанаас авах, ус, цахилгаан, дулааны асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг төлөвлөх шаардлагатай.

### 3.5. Тавдугаар бүлэг. Сэргээн босгох төлөвлөгөө

Энэ бүлэгт гамшгийн дараах хэрэгцээний үнэлгээнд тулгуурлан хүн амын нийгмийн асуудлыг нэн даруй шийдвэрлэх, нийгмийн үйл ажиллагааг хэвийн байдалд оруулах, хүний амьдрах анхдагч хэрэгцээ/орон байр, ундны ус, хоол хүнс, дулаан хувцас, түр хоргодох байр, эм, харилцаа холбоо, цахилгаан, дулаан, нийгмийн үйлчилгээ/-г хангах, учирсан хохирлыг арилгах, нөхөн барагдуулах, дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах зэрэг асуудлыг урт болон богино хугацаанд хэн хариуцаж хэрхэн шийдвэрлэх асуудлыг тусгана.

### 3.6. Зургадугаар бүлэг. Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах төлөвлөгөө

Энэ хэсэгт Засгийн газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ыг баримтлан орон нутагт хэрэгцээний үнэлгээ хийх, хүмүүнлэгийн тусламжийг хүсэх, хүлээн авах, мөнгөн болон материаллаг хандив тусламжийг хэн, ямар байгууллага хариуцах, байршуулах, хадгалах, хуваарилах, тээвэрлэх асуудлыг хэн хариуцаж, хэрхэн зохион байгуулах асуудлыг тусгана.

### 3.7. Хавсралт:

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралтыг тусад нь хавтаслаж дараах баримт бичгийг хавсаргана. Хавсралт хэсэг дараах бүтэцтэй байна. Үүнд:

#### 3.7.1 Тушаал шийдвэр, захирамжлалын баримт бичиг, гэрээ хэсэгт:

Энэ хэсэгт Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг байгуулсан шийдвэр, хамтран ажиллах байгууллагуудтай хийсэн гэрээний эх хувийг оруулна. Мөн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх захирамжийн төсөл, Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гарах захирамжлалын баримт бичгийн төслийг тухайн үед ашиглахаар боловсруулан хавсаргаж өгнө.



### 3.7.2 Холбоо, зарлан мэдээлэл хэсэгт:

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, Онцгой комиссын гишүүд, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдлагатай холбогдох утасны дугаар, гэрийн хаяг, сумдын удирдлагын утасны дугаар, Онцгой комисс, албадын зарлан мэдээллийн схем, зарлан мэдээллийн дуут дохионы техник хэрэгслийн байршил, хариуцах албан тушаалтан, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын удирдамж Бэлэн байдлын зэргүүдэд шилжих үед Засаг даргын Тамгын газар, Онцгой комиссын гүйцэтгэх үүргийн бэлэн байдлын зэрэг бүрээр зааж өгнө.

### 3.7.3. Хүч хэрэгсэл, нөөцийн судалгаа хэсэгт:

Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн судалгаа /орон нутгийн үндсэн хүч хэрэгсэл, бүсийн аймгуудын дайчлагдан ажиллах боломжтой хүч хэрэгслийн тоо, нутгийн захиргааны байгууллагууд, төрийн байгууллагууд, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг гэх мэт / болон нүүлгэн шилжүүлэлт хийсэн үед ашиглах бүх төрлийн нөөцийн судалгааг тусгана.

Хүч хэрэгсэл, нөөцийн нарийвчилсан судалгааг холбогдох гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн төлөвлөгөөнд тусгана. Тухайлбал, хүнс, хувцас, багаж хэрэгсэл, шатахуун, өвс, тэжээл, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлгийн байгууллагын нөөц гэх мэт нөөцийг жагсаалт, тоон үзүүлэлтээр гаргаж бичнэ.

### Барилга байгууламжийн судалгаа хэсэгт:

Орон нутагт байгаа улсын онц чухал объект, галын аюултай болон бусад барилга байгууламжийн байршил, хийц бүтээц, инженерийн шугам сүлжээ, ашиглалтын байдал, орц гарц зэргийг дэлгэрэнгүй тусгана.

### 3.7.4 Зураг, зураглалын хэсэгт:

Онцгой комиссын ажлын болон шийдвэрийн зураг, Орон нутгийн байр зүйн зураг /М1:200000, М1:100000/, Орон нутгийн план зураг, нисдэг тэрэг хөөрөх, буух боломжтой талбайн байршил, аврах үйл ажиллагааны бүдүүвч.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны суурьшлын бүсийн план зургийг гарган хавсаргана.

Дөрөв. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө  
боловсруулахад анхаарах зүйлс

4.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахдаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудтай хэн, ямар үүрэгтэй оролцох, аль

байгууллага удирдан чиглүүлэх эсвэл дэмжлэг үзүүлэх талаар зөвшилцөн бодитой боловсруулна.

4.2. Төлөвлөгөөг орон нутгийн хөгжлийн ойрын болон хэтийн төлөвлөгөө, гамшгийн давтамж, эрсдэл, эмзэг байдал, чадавхтай уялдуулан төлөвлөнө.

4.3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж дуусмагц төлөвлөгөөний дагуу дадлага, сургууль зохион байгуулж туршин, шаардлагатай хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулна.

---oOo---

Монгол Улсын Шадар сайдын  
2018 оны 10 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

## ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Нэг. Удиртгал

1.1. Энэхүү зааврын зорилго нь гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг нэгдсэн арга зүйгээр хангахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.

1.3. Гамшгаас хамгаалах улсын албаны төлөвлөгөө боловсруулах ажлыг гамшгаас хамгаалах улсын албаны даргын тушаалаар, гамшгаас хамгаалах орон нутгийн албаны төлөвлөгөөг орон нутгийн гамшгаас хамгаалах албаны даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг гүйцэтгэх бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд онцгой байдлын байгууллага, төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх мэргэжлийн анги, хуулийн этгээд, сайн дурын хэсэг, иргэний төлөөлөл байна. Онцгой байдлын газар, хэлтэс нь төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

1.4. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу төлөвлөж зарцуулна.

1.5. Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан онцгой комисст тайлагнана.

1.6. Төлөвлөгөөг улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдуулж боловсруулахаас гадна салбарын онцлогийг харгалзан бүлэг, хэсэг, зүйл, заалт нэмж болно.

1.7. Улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлага, зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж хянаж, тухайн албаны дарга батална.

1.8. Орон нутгийн гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар хянаж, тухайн албаны дарга батална.

1.9. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дараах тохиолдолд тодотгоно.  
- төлөвлөгөөний бүтэц, агуулгад өөрчлөлт орсон тохиолдолд,

- орон нутагт зохион байгуулж буй гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургуулиар,
- гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад илэрсэн дутагдал, сул талыг арилгах зорилгоор,
- аюулт үзэгдэл, осол болон бусад шаардлагатай үед
- гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед.

1.10. Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөг гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан хаагч тодотгоно.

1.11. Төлөвлөгөөг 3% үйлдэх бөгөөд гамшгаас хамгаалах алба, онцгой байдлын байгууллагад тус бүр нэг хувийг хадгалж, нэг хувийг орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хавсаргана.

#### Хоёр. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц

2.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө дараах бүлэгтэй байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл  
 Хоёрдугаар бүлэг. Танилцуулга  
 Гуравдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө

Дөрөвдүгээр бүлэг. Хор уршгийг арилгах төлөвлөгөө (аюулт үзэгдлийн төрөл бүрээр)

Тавдугаар бүлэг. Сэргээн босгох төлөвлөгөө

Хавсралт /захирамжлалын баримт бичгийн төсөл, зарлан мэдээллийн схем, хүч хэрэгслийн тооцоо судалгаа, нөөц, хангамжийн судалгаа, байр зүйн болон план зураг гэх мэт/

#### Гурав. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах аргачлал

3.1. Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Нийтлэг үндэслэл нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, баримтлах зарчим гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Төлөвлөгөөний зорилго хэсэгт:

Гамшигт тэсвэртэй хот суурин, хүрээлэн буй орчныг цогцлоох, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, хор уршгийг арилгах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, сэргээн босгох арга хэрхэн үр дүнтэй зохион байгуулах, гамшиг, осол, аюулт үзэгдэл тохиолдсон үед онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах бусад алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд хэрхэн дэмжлэг үзүүлэх, удирдлага зохицуулалтаар хангах, хамтран ажиллах асуудлыг гол зорилгоо болгож бичнэ.

Төлөвлөгөө боловсруулах зарчим хэсэгт:

Эрхэлсэн салбарын гамшгийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн, хэрэгжих үндэслэлтэй, оролцогч талуудын харилцан ажиллагаа, уялдааг хангасан, Монгол Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, бусад албадын төлөвлөгөөтэй уялдсан байх зарчмыг баримтална.

### 3.2. Хоёрдугаар бүлэг. Танилцуулга

Энэ бүлэг нь:

- албаны товч танилцуулга,
- гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалт гэсэн хэсгээс бүрдэнэ.

3.2.1. Гамшгаас хамгаалах улсын албаны товч танилцуулгын талаар бичнэ. Танилцуулгыг албан ёсны статистик тоо баримтыг үндэслэн хүснэгт, зурган болон бусад хэлбэрээр үзүүлнэ.

Албаны товч танилцуулга нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

-Тухайн салбарын хүчин чадал, хүний нөөц, тухайлбал, улсын албаны хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагын тоо, ажилтан, албан хаагчдын тоо, төрийн бус байгууллага, холбоод, салбарын төсөв зардал, барилга байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгслийн чанар байдал.

### 3.2.2. Гамшгаас хамгаалах удирдлага /штаб/, зохион байгуулалт хэсэгт:

Гамшгаас хамгаалах албаны удирдлага /штаб/, бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох талууд ямар үүрэг оролцоотой оролцохыг тодорхойлно. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, онцгой комисс, онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах албаны удирдлага /штаб/, мэргэжлийн ангийн бүтэц, зохион байгуулалт тэдгээрийн харилцан ажиллагаа, албаны штабын бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарь, гүйцэтгэх үүргийн талаар тусгана. Улсын албаны шуурхай штаб нь орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах талаар тусгана.

Гамшгаас хамгаалах улсын албаны удирдлага /штаб/, мэргэжлийн ангийн сургалт, бэлтгэлийн талаар мөн тусгана.

### 3.3. Гуравдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө

Гамшгаас хамгаалах улсын албаны бэлэн байдлыг хангах, харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор

ажиллах арга, ажиллагаа, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албаны штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, харьяа байгууллага, салбарын ажилтнуудыг сургаж, дадлагажуулах, мэргэжлийн анги, тусгай мэргэжлийн хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, гамшгийн нөөц бүрдүүлэх, гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах гэх мэт бэлтгэл, бэлэн байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааг төлөвлөж тусгана.

### 3.4. Дөрөвдүгээр бүлэг. Гамшгийн хор уршгийг арилгах төлөвлөгөө

#### 3.4.1. Гамшгийн хор уршгийг арилгах төлөвлөгөө (аюулт үзэгдлийн төрөл бүрээр)

Тухайн алба ажиллах гамшиг, осол, аюулт үзэгдлийн төрөл бүрээр үйл ажиллагааг хэрхэн шуурхай зохион байгуулах асуудлыг дэс дараалалтайгаар тусгана. Тухайлбал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журамд заасан чиг үүргийг тусгахаас гадна эрт зарлан мэдээлэх дохиог тухайн салбарын хэмжээнд дамжуулах, штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, ажилтнуудын бэлэн байдлыг хангах, хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх, хүч хэрэгслийг төлөвлөх, хуваарилах, шуурхай штаб, бүлэг томилох, мэдээ мэдээлэл цуглуулах, дамжуулах, ар тал, хангалтыг зохион байгуулах гэх мэт асуудлыг хэн, хэзээ, хэрхэн зохион байгуулах талаар төлөвлөгөөнд тусгана.

Гамшгаас хамгаалах улсын албаны штаб нь үүссэн цагийн байдалтай холбогдуулан улсын албыг хуульд заасны дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, гамшгийн үед албаны штабын бүрэлдэхүүнийг хуралдуулж гамшгаас хамгаалах улсын алба, мэргэжлийн ангиудыг гамшгийн голомтод томилж үүрэг гүйцэтгүүлэх болон аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд шаардлагатай хүч хэрэгслийг тодотгох, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа мэргэжлийн анги, бусад байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гамшгийн цагийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар дээд шатны байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад илтгэх гэх мэт үйл ажиллагааг Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Улсын албаны ажиллах нийтлэг журам"-д заасны дагуу үйл ажиллагаагаа төлөвлөж хэрэгжүүлнэ.

Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв, Нийслэлийн шуурхай удирдлагын төвөөр дамжуулан мэдээлэл солилцож, эрэн хайх, аврах, гал унтраах, эмнэлгийн яаралтай тусламжийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хяналт тавих, голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний болон нэрвэгдэгсдэд үзүүлэх бүх төрлийн хангалт (хоол хүнс, шатах тослох материал, байр сууц, эм тариа, хувцас, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл г.м.)-ыг зохион байгуулах, цугларах талбайд цугласан иргэдийг бүртгэх, зааварчилгаа өгөх, хэрэв шаардлагатай бол гамшгийн голомтоос иргэдийг нүүлгэн шилжүүлэх үед

хангалт зохион байгуулах, гамшгийн голомтод зам гарцыг чөлөөлж, хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын бүс тогтоох, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх зэрэг тухайн алба гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед онцгой байдлын байгууллагыг хэрхэн дэмжиж ажиллах, орон нутгийн албыг удирдлага, зохицуулалтаар хэрхэн хангах, ямар үүрэг гүйцэтгэх талаар тусгана.

#### 3.4.2. Гамшгаас хамгаалах дайчилгаа зохион байгуулах төлөвлөгөө

Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлах төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгавал зохино.

Улсын албаны гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн дайчилгааг хоёр үе шаттай явуулах, эхний ээлжинд тухайн албаны үндсэн хүч хэрэгсэл болох ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн ангийг өргөтгөн зохион байгуулах, нөхөн хангалт хийх зорилгоор бүх шатны Засаг даргын Тамгын газар, цэргийн штаб, эрүүл мэндийн газруудтай хамтран цэргийн хоёрдугаар үүрэгтэн буюу цэргийн насны цэргийн алба хаагаагүй иргэд, гамшгаас хамгаалах дүйцүүлэн алба хаасан тусгай мэргэжилтэй иргэд, оюутнуудыг дайчлах талаар тусгана.

Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын цэргийн хүч хэрэгслийг харилцан ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу үүрэг гүйцэтгүүлэх, шаардагдах ажилтнууд, хүч хэрэгслийг орон нутгаас дайчлан гаргах, тэдгээрийн хангалтын асуудлыг хэрхэн зохион байгуулах талаар энэ хэсэгт тусгана.

Хариу арга хэмжээг зохион байгуулахад дээр дурдсан үндсэн хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд дайчилгааны хоёрдугаар ээлжийг зохион байгуулж гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг өргөтгөн зохион байгуулах, нөхөн хангалт хийх зорилгоор сайн дурын бүлэг, хэсгийн хүн хүч, техник хэрэгслийг дайчилна.

Сайн дурын хэсгийн бие бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах албадын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцуулах талаар загварт заасны дагуу гамшгийн цар хүрээнээс хамаарч хаанаас, ямар хүч, хэрэгсэл, хэдий хугацааны дараа бэлэн болохыг нарийвчлан төлөвлөнө.

#### 3.5 Тавдугаар бүлэг. Сэргээн босгох төлөвлөгөө

Энэ бүлэгт нийгмийн үйл ажиллагааг хэвийн байдалд оруулах, хүн амын наад захын хэрэгцээг /эрхэлсэн салбарын үйл ажиллагааны хүрээнд/ хангах, учирсан хохирлыг арилгах, сэргээн босгох, дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах зэрэг асуудлыг урт болон богино хугацаанд, хэн хариуцаж, хэрхэн шийдвэрлэх асуудлыг төлөвлөж тусгана.

Гамшгаас хамгаалах улсын албаны штаб нь тухайн салбарын хохирлын талаарх мэдээллийг цуглуулах, мэдээлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ. Тухайлбал, Гамшгаас хамгаалах улсын алба нь Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай удирдлагын төв, улсын албаны шуурхай удирдлагын штабын холбооны мэдээллийн системийг ашиглан ерөнхий цагийн байдлын мэдээлэл, бусад шаардлагатай мэдээллийг цуглуулж, хохирол, хэрэгцээний үнэлгээ, дүн шинжилгээнд үндэслэн сэргээн босгох үйл ажиллагааны хэрэгцээ, шаардагдах зардал, хөрөнгийг яаралтай тодорхойлох талаар тусгана.

Хэрэв тухайн салбарын хохирлын хэмжээ нь дотоод нөөц боломжийн хүрээнд байна гэж үзвэл тухайн гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн хүчээр зохион байгуулах арга хэмжээг авах, харин гамшгийн хохирол нь тухайн салбарын дотоод нөөц боломжоос давсан тохиолдолд орон нутгийн болон Улсын онцгой комиссын оролцоотойгоор сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулах талаар тусгана.

### 3.6 Зургадугаар бүлэг. Хавсралт

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралтыг тусад нь хавтаслаж дараах баримт бичгийг хавсаргана. Хавсралт хэсэг дараах бүтэцтэй байна. Үүнд:

-Тушаал шийдвэр, захирамжлалын баримт бичиг, гэрээ хэсэгт:

Энэ хэсэгт гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг байгуулсан шийдвэр, хамтран ажиллах байгууллагуудтай хийсэн гэрээ, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх захирамжийн төсөл гэх мэт албаны даргаас гарах тушаал шийдвэрийн төслийг тухайн үед ашиглахаар боловсруулан хавсаргана.

-Холбоо, зарлан мэдээлэл хэсэгт:

Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдлагатай холбогдох утасны дугаар, гэрийн хаяг, орон нутгийн гамшгаас хамгаалах албаны удирдлагын утасны дугаар, албадын зарлан мэдээллийн схем, зарлан мэдээллийн дуут дохионы техник хэрэгслийн байршил, хариуцах албан тушаалтан, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын удирдамж Бэлэн байдлын зэргүүдэд шилжих үед албаны удирдлага юу хийх талаар бэлэн байдлын зэрэг бүрээр зааж өгнө.

-Хүч хэрэгсэл, нөөцийн судалгаа хэсэгт:

Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн судалгаа /албаны үндсэн хүч хэрэгсэл, дайчлагдан ажиллах боломжтой хүч хэрэгслийн судалгаа, холбогдох байгууллагууд, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги гэх мэт/ болон нүүлгэн шилжүүлэлт хийсэн үед ашиглах бүх төрлийн нөөцийн судалгааг тусгана.



Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги болон холбогдох байгууллагаас нарийвчилсан судалгааг гаргуулан авч төлөвлөгөөнд тусгана. Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн нөөц бүрдүүлэлтийг нарийвчлан тусгаж байгаа нөөцийг жагсаалт, тоон үзүүлэлтээр гаргаж бичнэ.

- Зураг, зураглалын хэсэгт:

Албаны даргын ажлын болон шийдвэрийн зураг, байр зүйн зураг /М1:200000, М1:100000/, Монгол Улсын план зураг, Нисдэг тэрэг хөөрөх, буух боломжтой талбайн байршил, аврах үйл ажиллагааны бүдүүвч гэх мэт.

Мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн план зургийг хэсэгчлэн гарган хавсаргана.

Дөрөв. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад анхаарах зүйлс

4.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахдаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талууд ямар үүрэгтэй оролцох, аль байгууллага удирдан чиглүүлэх эсвэл дэмжлэг үзүүлэх талаар зөвшилцөн бодитой боловсруулна.

4.2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж дуусмагц төлөвлөгөөний дагуу дадлага, сургууль зохион байгуулж туршин, шаардлагатай хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулна.

---oOo---

## БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

### Нэг. Удиртгал

1.1. Энэхүү зааврын зорилго нь төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлыг нэгдсэн арга зүйгээр хангахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх бөгөөд гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох удирдлагын баримт бичиг байна.

1.3. Аж ахуй нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлыг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг боловсруулна.

1.4. Нэг барилга байгууламжид олон төрлийн байгууллага, хүмүүс үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд уг барилгын үндсэн эзэмшигч тухайн барилгад үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллага, хувь хүмүүстэй хамтран гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулна.

1.5 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад орон нутгийн онцгой байдлын байгууллага мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

1.6. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу төлөвлөж зарцуулна.

1.7. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг байгууллагын гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ, тойм судалгаанд тулгуурлан харьяа орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдуулж боловсруулна.

1.8. Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага хянаж, тухайн байгууллагын дарга, захирал батална.

1.9. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дараах тохиолдолд тодотгоно.

- төлөвлөгөөний бүтэц, агуулгад өөрчлөлт орсон тохиолдолд,
- орон нутагт зохион байгуулж буй гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургуулиар,

- гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад илэрсэн дутагдал, сул талыг арилгах зорилгоор,
- аюулт үзэгдэл, осол болон бусад шаардлагатай үед
- гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед.

1.10. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тухайн байгууллагын удирдлагын томилсон ажлын хэсэг, ажилтан тодотгоно.

1.11. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд ажлын тусгай горимд шилжих, ажиллах төлөвлөгөөтэй байх бөгөөд энэхүү төлөвлөгөө нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

1.12. Аж ахуйн нэгж байгууллагууд болзошгүй гамшгаас сэргийлэх, онцгой нөхцөл байдал тохиолдсон үед бэлэн байх, гамшгийн дараа нөхөн сэргээх арга хэмжээ авах үйл ажиллагааг зохион байгуулах, иргэдэд үйлчилгээ тасралтгүй үзүүлэх зорилгоор “Бизнесийн тогтвортой ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулж хавсаргана.

#### Хоёр. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц

2.1. Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө дараах бүтэцтэй байна. Үүнд:

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Танилцуулга

Гурав. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө

Дөрөв. Аюулт үзэгдэл, гамшиг, ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө

Тав. Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө

Зургаа. Хавсралт

2.2. Байгууллагын үйл ажиллагааны онцлог, хүчин чадлаас хамааран төлөвлөгөөний бүтэцэд нэмэлт хэсэг оруулж болно.

Гурав. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний агуулга,  
боловсруулах аргачлал

3.1. Нийтлэг үндэслэл хэсгийг боловсруулах:

Энэ хэсэгт гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго, зарчим, хамрах хүрээг тодорхойлж тусгана.

Байгууллагын ажилтан, албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг гамшгийн аюулаас авран хамгаалах, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, гамшгийг хохирол багатай даван туулах,

сэргээн босгох, иргэдэд үйлчилгээ тасралтгүй олгох асуудлыг гол зорилгоо болгоно.

Байгууллагын эрсдэл, эмзэг байдал, чадавхын үнэлгээнд тулгуурласан, хэрэгжих үндэслэлтэй, ажилтан, албан хаагчид, салбар нэгжүүдийн харилцан ажиллагаа, оролцоог хангасан байх зарчмыг баримтална.

Хамрах хүрээ хэсэгт гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд салбар нэгж, хувь хүн ямар үүрэг оролцоотой оролцохыг товч дурдана.

### 3.2. Танилцуулга хэсгийг боловсруулах:

Танилцуулга хэсэгт байгууллагын байршил, үйл ажиллагаа, аюулт үзэгдэл, ослын үеийн удирдлага, зохион байгуулалт, бүтэц, орон тоо, барилга байгууламжийн хийц бүтээц, инженерийн шугам сүлжээний үзүүлэлт, эрсдэл, эмзэг байдал, чадавхын үнэлгээ зэргийг тусгана. Мөн байгууллагын салбар нэгжийн гүйцэтгэх чиг үүргийг товч, тодорхой бичнэ.

3.3. Байгууллагын гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө хэсгийг боловсруулах:

Энэ бүлэгт Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан бүтцийн болон бүтцийн бус үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал хамаарна.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланд тусгасан зөвлөмжийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг жил бүр төлөвлөж шаардагдах хөрөнгийг тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд тусгана.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөнд ажилтан, албан хаагчдад гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, мэдлэг, дадлага олгох арга хэмжээг төлөвлөнө. Тухайлбал, хүн нэг бүрийн үүргэвч бүрдүүлэх, зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, аюулгүй талбайд цугларах, нүүн шилжих, хүн нэг бүрийн гүйцэтгэх үүрэг, гамшгаас хамгаалах багаж хэрэгслийг бүрдүүлэх, ажиллуулах арга гэх мэт бэлэн байдлыг хангахтай холбоотой сургалт, дадлагыг хэн, хэрхэн зохион байгуулах талаар мөн дурдана.

3.4. Аюулт үзэгдэл, гамшиг, ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө хэсгийг боловсруулах:

Орон нутагт томоохон гамшиг, осол тохиолдсон үед болон тухайн барилга байгууламжид гал түймэр, үер, хөлдөлт, цацраг, химийн хорт бодис алдагдах, барилга байшин нурах зэрэг аюул, осол тохиолдсон үед шуурхай ажиллагааг хэрхэн зохион байгуулах дэс дарааллаар төлөвлөнө. Тухайлбал, Зарлан мэдээлэл дамжуулах, шуурхай штаб, бүлэг томилох, хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх, хүч хэрэгслийг төлөвлөх, хуваарилах, мэдээ мэдээлэл цуглуулах,

дамжуулах, ар тал, хангалтыг зохион байгуулах гэх мэт асуудлыг хэн, хэзээ, хэрхэн зохион байгуулах талаар төлөвлөгөөнд тусгана.

### 3.5. Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах:

Барилга дотор буй хүмүүсийг гамшиг, ослын үед хэрхэн аюулгүй, түр цугларах талбайд гаргах, бүртгэх, нүүлгэн шилжүүлэх, хангалт хэрхэн зохион байгуулах талаар тусгана. Байгууллагын цахим мэдээлэл, санхүүгийн болон бусад чухал баримтыг мөн хэрхэн хадгалах, зөөвөрлөх талаар төлөвлөнө.

### 3.6. Хавсралт хэсгийг боловсруулах:

3.6.1. Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралт дараах хэсгээс бүрдэнэ.

3.6.1.1. Тушаал, шийдвэр, журам /штаб, мэргэжлийн анги байгуулсан тушаал/, ажлын тусгай горимд шилжүүлэх тушаалын төсөл гэх мэт.

3.6.1.2. Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч. Хүн нэг бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж тусгасан байна.

3.6.1.2. Холбоо, зарлан мэдээллийн схем /байгууллагын удирдлага, ажилтан албан хаагчдад хэрхэн мэдээлэл хүргэх зарлан мэдээллийн схем, холбогдох утасны дугаар, гэрийн хаяг гэх мэт/.

3.6.1.3. Хүч хэрэгсэл, нөөцийн судалгаа /тухайн байгууллагаас аюулт үзэгдэл, гамшиг, ослын үед орон нутгийн онцгой комисс, онцгой байдлын байгууллагад дайчлагдан ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгаа/.

3.6.1.4. Ажлын болон план зураг /гамшгаас хамгаалах удирдлагын ажлын зураг, барилга байгууламжийн план зураг, давхруудын зураг, цугларах цэг, зарлан мэдээллийн дохио дамжуулах хэрэгсэл, барилгаас гарах аюулгүйн гарцын зураглал гэх мэт/.

3.6.1.5. Ажлын тусгай горимоор ажиллах төлөвлөгөө. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/291 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, цуцлах журам"-д нийцүүлэн энэхүү төлөвлөгөөг өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулсан байна.

3.6.1.6. Бизнесийн тогтвортой ажиллагааны төлөвлөгөө. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахад "Аж ахуйн нэгж байгууллага, жижиг, дунд үйлдвэрийн гамшигийн удирдлагын тогтолцоо ба бизнесийн тогтвортой ажиллагааны төлөвлөгөөг олон улсын аргачлалаар боловсруулах гарын авлага 1, 2, 3, 4"-ыг ашиглаж болно.

Дөрөв. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө  
боловсруулахад анхаарах зүйлс

4.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахдаа байгууллагын эрсдэл, эмзэг байдал, чадавхтай нягт уялдуулан амьдралд хэрэгжихүйц байхаар боловсруулна.

4.2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлагдсаны дараа төлөвлөгөөний дагуу дадлага, сургууль зохион байгуулж туршин, шаардлагатай хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулна.

---oOo---